

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Туул голын сав газрын захиргаа

Нэгжийн нэр:

Албан тушаалын нэр:

Уул уурхай, эрчим хүчний ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-6

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Сав газрын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх, уул уурхайн үйлдвэрлэл, эрчим хүчний үйлдвэрлэлд усны нөөцийг зүй зохистой ашиглах, усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйгээр хангах, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u>			
<p>1.Уул уурхай, эрчим хүчний салбарт ус хэрэглээний оновчтой менежментийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэх.</p> <p>2.Уул уурхай, эрчим хүчний салбарын ус ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийх, мэдээллийн санг бүрдүүлэх, сайжруулах.</p> <p>3.Усны нөөцийг зохистой ашиглах, менежментийг сайруулах, усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх.</p> <p>4.Албан тушаалын чиг үүргийн дагуу гүйцэтгэх бусад ажил.</p>			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Сав газрын хэмжээнд гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн хязгаарт багтаан ашиглуулах;	Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Сав газрын хэмжээнд ашиглах боломжит усны нөөц, ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллах;	Усны нөөцийг хомсдох, бохирдохоос сэргийлсэн байна.	Г
	3.Өртөг, зардал, бохирдол багатай технологийн судалгааг хийх, олон улсын туршлагыг нэвтрүүлэх.	Судалгааны ажлыг хийж, нэвтрүүлэх арга замыг судалсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Уул уурхай, эрчим хүчний салбарын ус ашиглалтын байдалд дүн шинжилгээ хийх;	Дүн шинжилгээ нь нотолгоонд тулгуурласан үндэслэл бүхий байна.	Г
	2.Уул уурхай, эрчим хүчний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгжийн судалгааг сав газрын хэмжээнд нэгтгэн гаргах;	Ус ашиглагч, хэрэглэгчийн судалгаа, нотолгоотой бодитой байна.	Г
	3.Сав газрын ус ашиглалтын байдалд хяналт тавьж, усны нөөцийг хэмнэлттэй дахин ашиглах, тоолууржуулах ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах.	Усыг хэмнэх, дахин ашиглах, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Усны тухай хууль болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль түүнийг дагалдан гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчилах, тайлагнах;	Усны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, тайлан мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргасан байна.	Г



	2.Сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход сав газрын захиргааны саналыг үндэслэлийг боловсруулах, хэрэгжүүлэх;	Санал нь үндэслэлтэй, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрт нийцсэн байна.	Г
	3.Байгаль орчныг хамгаалах, баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх талаар санал боловсруулах.	Боловсруулсан санал нь хуульд нийцсэн, үндэслэлтэй байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг ханган, өдөр тутмын ажлыг мэргэшлийн түвшинд чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;	Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Г
	3.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх.	Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргахгүй ажилласан байна.	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> - гидромеханик /071504/; - гидрогеологи, инженер геологи /053204/; - геофизик /053205/; - ус судлал /052202/; - сэргээгдэх эрчим хүч /071301/; - усны барилга байгууламжийн инженер; - усны нөөц, экологи; - усны менежмент. 	
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах;



Ур чадвар		- бусад
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах; - саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - бусад
Бусад	- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн аргыг ашиглах; - бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах; - кирилл болон үндэсний бичгээр уншиж, бичих чадвартай байх; - жендерийн тэгш байдлыг хангах.	

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

.....


<p><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></p>	<p><u>Бусад харилцах субъект</u></p> <ul style="list-style-type: none"> - Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар; - Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар; - Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын алба, байгаль орчны хяналтын улсын байцаагч; - Бусад сав газрын захиргаад; - Сав газрын зөвлөлүүд; - Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа; - Усны мэргэжлийн байгууллага; - Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн газар, төрийн байгууллага;
--	---




	<ul style="list-style-type: none"> - Их, дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллага; - Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага; - Бусад яамд, агентлагууд.
--	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
---	--

<u>Албан тушаал:</u> Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга  - О.ГАНТУЛГА 20 20 оны 10 дугаар сарын 20 ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> 20 12 23 <u>Дугаар:</u> 2
---	---

Албан тушаалын тодорхойлолт баталсан:

<u>Байгууллагын нэр:</u> ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГАА <u>Шийдвэрийн огноо:</u> 2021/01/18 <u>Дугаар:</u> А/01 ДАРГА 20 21 оны 01 дугаар сарын 18 ны өдөр	 / Б.ОЮУНБОЛД /
--	---

